



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/160

Мандалговь

“Үндэсний бичиг үсгийн баяр 2019”
Монгол бичгийн их сорилго уралдаанд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын /а/, “Монгол хэлний тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105, 2018 оны 46 дугаар зарлиг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, аймгийн ИТХТ-ийн 2014 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний бичиг” аймгийн дэд хөтөлбөрийн 18 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Үндэсний бичиг” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион явуулдаг “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Уралдаанд шаардагдах шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Шагналын зардалд шаардагдах 765000 (долоон зуун жаран таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819044

Аймгийн Засаг даргын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн захирамжийн хавсралт



УРАЛДААНД ШААРДАГДАХ ШАГНАЛЫН ЗАРДАЛ

Д/Д	Нэр	Төрөл	Нэгжийн үнэ	Тоо ширхэг	Нийт
1	Сурагч	1-р байр	20,000	7	140,000
2		2-р байр	15,000	7	105,000
3		3-р байр	10,000	7	70,000
4	Багш	1-р байр	200,000	1	200,000
5		2-р байр	150,000	1	150,000
6		3-р байр	100,000	1	100,000
Дүн				24	765,000